

БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГА М.БАЯРСҮХ

БАТЛАВ.
“ИТГЭЛТ ТӨМӨР ХЭЛХЭЭ” ХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.МӨНХ-ОЧИР

“НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ХҮРЭЭЛЭНГИЙН БАЙГУУЛАМЖ, ТОХИЖИЛТ”
-ЫН АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар № ДУГАДЦСЗДТГ/202301008

Дэлгэрцогт сум

Нэг талаас [Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГазар] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 11 дүгээр хороо 7 дугаар хороолол Ногоон нуур, 517- 135 тоот “ИТГЭЛТ ТӨМӨР ХЭЛХЭЭ” ХХК ны гүйцэтгэх захирал Цогтбаатар овогтой Мөнх-Очир] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 04 дугаар сарын 20-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт”-ын ДУГАДЦСЗДТГ/202301008 -г (цаашид “ажил” гэх) 118,222,281 (Нэг зуун арван найман сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун наян нэгэн) (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.
3. Гэрээний үнэ санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл, гүйцэтгэлийн тайланг үндэслэн 30%, ажлын явцын үр дүнг үндэслэн 30%, ажлаа комисст хүлээлгэн өгсний дараа 40% байхаар санхүүжилтийг олгох ба ажлын 10 хоног дотор санхүүжилт хийнэ.
4. Гэрээний нийт дүн: 118.222.281 төгрөг. Үүнээс:

Барилга угсралтын ажил:	97.866.193
НӨАТ	9.786.619
Нормчлолын сан	176.159
Захиалагчийн албаны зардал	1.957.324
Магадалшгүй ажил	1.957.324
Зохиогчийн хяналтын зардал	978.662
Зураг төсвийн үнэ	5.500.000

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө: 2023 онд 118.222.281

Захиалагчийг төлөөлж:


Нарантунгалаг

Гүйцэтгэгчийг төлөөлж:


Ц.Мөнх-Очир

5. Гүйцэтгэгч нь "Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт"-ын ажлыг 2023 оны 05 сарын 01 -ий өдөр эхэлж, 2023 оны 06 сарын 15 өдөр ашиглалтад оруулна.
6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Бусад шаардлагатай баримт бичиг
 - Тендер;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Техникийн тодорхойлолт
 - Ажлын үе шатны ажлын хуваарь;
 - Ажлын зураг /Гүйцэтгэлийн зургаар/;
 - Санхүүжилтийн хуваарь;
 - Ажил гүйцэтгэх хуваарь
7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
11. Тохижилтын ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.
12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.
13. Гүйцэтгэгч нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5, 6.9-т заасны дагуу мэдээллийг оруулах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Захиалагчийг төлөөлж:

 С. Нарантунгалэг

Гүйцэтгэгчийг төлөөлж:

 Ц.Мөнх-Очир



14. Тохижилтын ажил гүйцэтгэгч компани товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацааны мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулах, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг ажил хийгдэж буй талбайд байршуулж аюулгүй ажиллагааг бүрэн хангах. Байршуулаагүй тохиолдолд санхүүжилтийг олгохгүй.

Маргаан шийдвэрлэх

15. Энэхүү гэрээний холбоотой талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

16. Хэрвээ санал зөрөлдөөнийг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗДТГ-ЫН ДАРГА С. НАРАНТУНГАЛАГ
Утас: 94889922



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


МЕНЕЖЕР: Н.МЯГМАРДОРЖ
Хаяг: Улаанбаатар хот СХД 2-р
Хүнсчидийн 37-10



Утас: 90000042, 89801331

Данс: Хаан банк: 5692274433
Регистрийн дугаар: 3766373

Захиалагчийг төлөөлж:

 С. Нарантунгалаг

Гүйцэтгэгчийг төлөөлж:

 Ц.Мөнх-Өчир

